



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ



ДЭЛХИЙН БАНК
ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП



УХААЛАГ ЗАСАГ-2



Digital Nation Ambassador

Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх гарын авлага

ЦАХИМ ДЭМД ХЯЗГААРГУЙ
АХИМД ХОРОЙГУЙ



2024 он





Энэхүү гарын авлагыг Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны "Ухаалаг засаг 2" төслийн Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд бэлтгэн боловсруулав.

Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөрийн баг бүрэлдэхүүн:

Ахлах зөвлөх :

Х.Саруул

Хөтөлбөр хариуцсан зөвлөх бөгөөд хөтөлбөр, гарын авлагыг боловсруулсан:

Б.Оюунцэцэг

Сургалт, үйл ажиллагаа хариуцсан зөвлөх:

Д.Оюумаа

Маркетинг болон сурталчилгаа хариуцсан зөвлөх:

Б.Энхмөрөн

Редактор:

Б.Оюундэлгэр

Хэвлэлийн эх, дизайн бэлтгэл:

Ц.Хосбаяр

Өмнөх үг

Дэлхий дахинд цахим шилжилтийн давлагаа явагдаж улс орнуудын хөгжил дэвшил нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбараас шууд хамаарч байна. Дэлхийн өнцөг булан бүрээс орон зай, цаг хугацаанаас үл хамааран интернэтэд холбогдох, тоон тоног төхөөрөмж болон мэдээллийн технологийн дэвшлийг ажил, амьдралдаа ашиглаж байна. Сүүлийн арван жилд харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшилтэт шийдэл болох хиймэл оюун ухаан, интернэт, машин-суралцах, хөдөлгөөнт холбооны аппликейшнүүд, нанотехнологи гэх мэт хэрэглээ эрчимтэй нэвтэрч иргэд, аж ахуйн нэгжүүдийн өдөр тутмын амьдралд чухал нөлөө үзүүлээд байна.

Өнөөдөр Монгол Улсын иргэд гар утас, компьютер төдийгүй бүхий л электрон төхөөрөмжийг интернэтэд холбон, хоорондоо мэдээлэл солилцохын зэрэгцээ боловсрол, эрүүл мэнд, төрийн болон бизнес, санхүүгийн үйлчилгээг авч байна. Гэвч энэ нь бүх иргэдийг хамарч, хангалттай үр дүнд хүрч чадахгүй, цахим мэдлэгийн ялгаа гарсаар байгаа юм. Үүнээс шалтгаалан залуу үе болон ахмад настай иргэдийн хооронд тоон хуваагдал үүсээд байна.

Иймд 100 оюутан, залуус, 30 ахмад настнуудыг сайн дурын Үндэсний цахим элч (ҮЦЭ)-ээр сонгон шалгаруулж, сургагч багш болгосноор тэдний тусламжтайгаар 1000 ахмад настай иргэд, цаашлаад улсын хэмжээнд 10,000 иргэд, тэр дундаа хөдөө орон нутаг, алслагдсан бүс, сумын иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж, ахмад настай иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөрийг ийнхүү хэрэгжүүлж байна.

Энэхүү сургалтын гарын авлагыг боловсруулахад мэргэжил, арга зүйн чиглэлээр дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, И-Монгол академи УТҮГ болон сургалт зохион байгуулахад туслалцаа үзүүлсэн Монголын ахмадын холбооны хамт олонд гүн талархлаа илэрхийлье.



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ



Эрхэм хүндэт ахмадууд аа

Ажил амьдралын арвин их туршлагатай ахмад буурлууд та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэж, энх тунх, ирээдүйтэйгээ хөл нийлүүлэн алхах өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье!

Өгөөдэй хаанаас уламжлагдан ирсэн шуудан, харилцаа холбооны салбар өнөө цагт үсрэнгүй хөгжиж, бүх салбарын хөгжлийн хурдасгуур болж байна.

Монгол Улсын Засгийн газар төрийн үйлчилгээг иргэддээ хурдан шуурхай, хүнд сурталгүй, ил тод хүргэх үүднээс цахим шилжилтийг эрчимжүүлж, хүн бүр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлсээр байна.

Гар утас, компьютероос төрийн цахим үйлчилгээг авах нь залуучуудын хувьд энгийн ур чадварт тооцогдож байгаа ч ахмадуудын маань хувьд энэ чиглэлийн сургалт, зөвлөн туслах үйл ажиллагаа зайлшгүй зохион байгуулах хэрэгцээ шаардлага байна.

Иймд Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны "Ухаалаг засаг 2" төслийн Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ахмадуудад цахим ур чадвар олгох сургалтыг үе шаттай зохион байгуулж байна.

Төслийн хүрээнд 100 залуус, 30 ахмадуудыг сайн дурын "Үндэсний Цахим Элч" – ээр тодруулан, сургагч багш болгон бэлтгэж, тэдний тусламжтайгаар 1000 ахмад, алслагдсан бүс нутгийн 10,000 иргэдийн цахим ур чадварыг хөгжүүлэхээр бид зорьж байна.

Мэдлэг ур чадвараа дээшлүүлэн суралцаж буй ахмадууд маань төр засгийн бодлого, санаачилгыг дэмжин, энэхүү төслийн хүрээнд олж авсан өргөн мэдлэг, арвин туршлага, ур чадвараа бие биедээ хуваалцах үйлсэд үнэтэй хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэнд энх тунх, аз жаргалтай, урт удаан наслахын өлзийт ерөөл өргөн дэвшүүлье!

**Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
Ц. БААТАРХҮҮ**

Гарчиг

ҮНДЭСЛЭЛ	8
Зарчим	9
ХАМРАХ ХҮРЭЭ	9
ГАРЫН АВЛАГЫГ АШИГЛАХ ЗААВАР	11
СУРГАЛТЫН ӨМНӨХ АСУУМЖ	12

1 УХААЛАГ ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

1.1. Андроид/Ай фон гар утас	17
1.2. Утас асаах/унтраах	18
1.3. Утасны хонх тохируулах	19
1.4. Утасны дэлгэцийн гэрэл / үсгийн хэмжээ тааруулах / хэл солих.....	21
1.5. Интернэт сүлжээнд холбох wifi	24
1.6. Play store-оос аппликейшн татах.....	26
1.7. App store-оос аппликейшн татах.....	28
1.8. Гар утасны нууцлал	30
1.9. Apple ID шинээр үүсгэх	32
1.10. Дэлгэц цэгцлэх - аппликейшн хооронд бүлэглэх.....	34
1.11. Утасны багтаамж нэмэх / аппликейшн устгах /	35

2 ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ

2.1. Интернэт браузер суулгах.....	37
2.2. Google account шинээр үүсгэх.....	42
2.3. Google account нэмэх, нууц үг сэргээх.....	45
2.4. Google search - гүүгл хайлт хийх	51
2.5. Нууц үгийн тухай ойлголт	55
2.6. Google calendar	56
2.7. Google photos	60
2.8. Gmail	62
2.9. Google drive.....	68
2.10. Google maps	72
2.11. Мэдээллийг таних, эх сурвалжийг баталгаажуулах.....	74

3 ХАРИЛЦАА ХОЛБОО

3.1. Фэйсбүүк хаяг нээх	76
3.2. Бусадтай олон нийтийн сүлжээг ашиглах, онлайнаар харилцах	81
3.3. Цахим залилангаас сэргийлэх.....	84
3.4. Бусад олон нийтийн сүлжээ	85
3.5. Бусад видео хэрэгсэл	86
3.6. Google meet.....	86
3.7. Viber.....	90
3.8. Telegram.....	92
3.9. Zoom	94
3.10. Кибер аюулгүй байдлын хуулийн тухай	97
3.11. Давхар шатлалт хамгаалалт	98

4	ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100
	4.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн тухай	101
	4.2. E-Mongolia аппликейшн ашиглах	102
	4.2.1. E-Mongolia цаг агаар	105
	4.2.2. E-Mongolia эрүүл мэнд	105
	4.2.3. E-Mongolia аялал	106
	4.2.4. E-kids	107
	4.3. Хүний хувийн мэдээллийг хамгаалах хуулийн тухай	108
	4.4. E-business	111
	4.5. D-Parliament	112
	4.6. EVarimt	113
	4.7. И-Татвар	114
	4.8. Тоон гарын үсэг/ Цахим гарын үсэг	115
	4.9. GSign аппликейшн - цахим гарын үсэг	116
	4.10. E-Mongolia аппликейшнд хэрхэн тоон гарын үсгээр нэвтрэх	118
	4.11. И-Халамж систем	118
	4.12. Ub smart bus	122
5	БАНК ТӨЛБӨР ТООЦОО	124
	5.1. Интернет банк	125
	5.2. Төрийн банкны аппликейшны хэрэглээ	125
	5.3. Хаан банкны аппликейшны хэрэглээ	129
	5.4. Цахим банкны аюулгүй байдлын зөвлөмж	134
	5.5. Unitel аппликейшн татах	136
	5.6. Skytel аппликейшн	143
	5.7. Mobicom аппликейшн	148
	5.8. Social pay	150
	5.9. Toki аппликейшн	151
	5.10. Онлайнаар бараа худалдаж авахад анхаарах зөвлөмжүүд	154
6	КОНТЕНТ БҮТЭЭХ	156
	6.1. Богино контент буюу рийл хийх	157
	6.2. Carcut	158
7	КОМПЬЮТЕР	160
	7.1. Компьютерын тухай товч мэдээлэл	161
	7.2. Компьютерын зөв хэрэглээ	161
	7.3. Монгол хэл дээр хурдан шивж сурах дасгал	161
	7.4. Компьютерын хэрэглээний программ	162
	7.4.1. Microsoft Word	162
	7.4.2. Microsoft Excel	162
	7.4.3. Microsoft Power Point	162
	7.5. Компьютерын хэрэглээний гарын авлагын тухай	162
	УХААЛАГ ЗАСАГ-2 ТӨСЛИЙН ТУХАЙ	163
	САНАЛ, ХҮСЭЛТ, ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЕХАНИЗМ	165
	АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	166

ҮНДЭСЛЭЛ

Орчин үед гар утас, компьютертой харьцах, хэрэгцээт мэдээллээ олж авах нь өдөр тутмын, энгийн чадвар болсон бөгөөд цахим хэрэглээ нь дэлхий дахинд маш хурдацтай хөгжиж, улс орнуудын нийгэм, эдийн засаг, хүн ба улсын хөгжлийн хурдасгагч чухал хүчин зүйл болж байна. Гэвч техник, технологи, тоног төхөөрөмж, цахим ур чадварын суурь ойлголтгүй, сургалтын хүртээмжгүй байдал нь олон хүний боломжийг хязгаарлаж, хувь хүн болон нийгмийн хүрээнд ихээхэн хохирол учруулж байна. Үүнээс шалтгаалан ард иргэд цахим ур чадвар эзэмшин, цахим орчны хэрэглээний давуу талд суралцаж, ажил, амьдралдаа тусгах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Иймд Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа 2050” бодлогын “Цахим үндэстэн” зорилтын хүрээнд цахим шилжилтийг дэмжих ажлуудыг шат дараатай хэрэгжүүлж эхэлсэн. Үүний нэг жишээ нь И-Монгол төрийн нэгдсэн үйлчилгээний системээр дамжуулан төрийн олон үйлчилгээг иргэдэд хүндрэл чирэгдэлгүй цахимаар авах боломжийг олгосон хэдий ч ахмад настай иргэдийн хэрэглээ хамгийн бага байна.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 141 дүгээр тогтоолоор “Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээ”-г баталсан ба тус бүтцийн хүрээнд заасан чадамжуудыг нарийвчлан судалж, цахим ур чадваруудыг үнэлэх аргачлал, сургалтын хөтөлбөр боловсруулж, түгээх ажлыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарт тус тус даалгасан.

Тиймээс бид ахмад настай иргэдийн өдөр тутмын амьдралд зайлшгүй шаардлагатай цахим ур чадварыг залуу үеийн оролцооны тусламжтайгаар нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх, цахим эдийн засгийн хүрээг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү гарын авлагыг боловсруулав.

ЗАРЧИМ

Бид ахмад настай иргэдийнхээ өдөр тутмын хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн, цахим ур чадварыг нь нэмэгдүүлэх энэхүү сургалтын гарын авлагыг боловсруулахдаа дараах зарчимд тулгуурлан боловсруулав.

1

Ахмад настай иргэдийн ахуй амьдрал, эрхэлдэг ажил хөдөлмөрт хэрэгцээтэй, ач холбогдолтой байх.

2

Бүтээлч байдал, хамтын ажиллагааг дэмжсэн байх.

3

Иргэдийн нийгэм болон цахим орчинд дасан зохицох, өсөн дэвших, бие даан суралцахад дэмжлэг үзүүлэх.

4

Ахмад настай иргэдийн суралцах онцлогт тохирсон, хувь хүний болон нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх.

5

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, чиг хандлагад нийцсэн байх.

6

Ахмад настай иргэд болон сайн дурын оюутан залуустай эрх тэгш, хүртээмжтэй харилцан, ёс зүйн хэм хэмжээсийг мөрдлөг болгосон байх.

ХАМРАХ ХҮРЭЭ

Бид ахмад настай иргэдэд чиглэсэн сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсруулахдаа олон улсын амжилттай хэрэгжсэн туршлагууд болох

- Сингапур улс - Мэдээлэл технологийн санаачилга (Silver IT Infocomm Initiative);
- Шинэ Зеланд улс - Таатай наслах (Age Friendly);
- Австрали улс - Холбоотой байх (Be Connected);
- Их Британи улс - Цахим аваргууд (Digital Champions) төслүүдийг судалж, сургалтын хөтөлбөр, агуулга, үнэлгээний аргачлал зэрэгт харьцуулалт хийсний үндсэн дээр боловсруулав.

Мөн түүнчлэн "И-Монгол академи" УТҮГ, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Хүрээ мэдээлэл холбоо, технологийн дээд сургууль болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны мэргэжилтэн, экспертүүдийн саналыг тусгасан ба бататгах зорилгоор хүн төвтэй дизайн аргачлал (Human Centered Design Approach)-ыг ашиглан хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдөр Улаанбаатар хотын 50 ахмад настай иргэдтэй уулзалт (focus group discussion) ярилцлага хийж, сургалтын агуулгын нийцлийг бататгасан.

Амьдрал, ажил хөдөлмөрт зайлшгүй шаардлагатай суурь цахим ур чадварууд гэдэгт дараах агуулгыг ойлгоно.

1 Харилцаа холбоо - Онлайнаар харилцах, хамтран ажиллах, мэдээллээ хуваалцах.

2 Асуудал шийдвэрлэх - Цахим хэрэгсэл, онлайн үйлчилгээг ашиглан асуудлуудын шийдлийг олох.

3 Үйлчилгээ авах - Цахимаар бараа, ажил, үйлчилгээ худалдах, худалдан авах, банкны гүйлгээгээ удирдах, төрийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авах.

4 Мэдээлэл, агуулга контентыг зохицуулах - Цахим мэдээлэл контентыг найдвартайгаар олох, удирдах, хадгалах, контент боловсруулах /видео хийх, зураг эвлүүлэх гэх мэт/

5 Мэдээллийн аюулгүй байдал - Цахим орчинд аюулгүй, хуулийн хүрээнд, итгэл дүүрэн оролцох.



ГАРЫН АВЛАГЫГ АШИГЛАХ ЗААВАР

Энэхүү гарын авлага нь суурь болон ахисан гэсэн хоёр түвшний агуулга бүхий сэдвүүдээс бүрдэх ба уншигч та суурь эсхүл ахисан түвшний сэдвүүдийг үзэхээс өмнө тухайн түвшинд хамаарах сургалтын өмнөх асуулгыг бөглөж өөрийн түвшингээ тодорхойлохыг хүсье.

Ингэснээр та өөрийн мэдэхгүй байгаа сэдвүүдийг тодорхойлох ба тухайн сэдвийн агуулгыг шууд үзэх боломжтой.

Мөн суурь, ахисан түвшний агуулгаа бүрэн үзэж дууссаны дараагаар сургалтын дараах асуулгыг бөглөж, өөрийн сурсан мэдлэгээ бататгаарай.

	Суурь түвшин	Ахисан түвшин
	Цахим иргэн	
Ухаалаг гар утасны хэрэглээ	Утас асаах/унтраах, утасны хонх, фонт өөрчлөх, WI-FI сүлжээнд холбох, утсандаа шинэ аппликейшн татаж авах, гар утасны нууцлал	Дэлгэц цэгцлэх - аппликейшн хооронд бүлэглэх, аппликейшн хоорондын шилжилт
Интернэтийн хэрэглээ	Интернэт хөтөч суулгах, Gmail бүртгэл шинээр үүсгэх, нэмэх, нууц үг сэргээх, Google search, calendar, photos, Gmail ашиглах	Google Drive, Google Maps өдөр тутмын хэрэглээнд ашиглах
Харилцаа холбоо	Оператор компанийн дата сүлжээг ашиглах, олон нийтийн сүлжээ, аппликейшн татах, онлайн дуудлага, видео дуудлага хийх, социал платформ дээр тохиргоо хийх, Google meet, Viber ашиглах	Zoom, Telegram ашиглах, давхар шатлалт хамгаалалт, Кибер аюулгүй байдлын хуулийн тухай
Төрийн үйлчилгээ	Төрд байгаа хувийн мэдээлэлдээ хяналт тавих, И-Монгол аппликейшн ашиглах, Эрүүл мэндийн үйлчилгээнд хандах, И-кидс аппликейшн ашиглах	E-business, d.parliament.mn, И-Баримт, И-Татвар, тоон болон цахим гарын үсгийн хэрэглээ
Банк, төлбөр тооцоо	Банкны аппликейшн ашиглах, төлбөр тооцоо хийх, Qraу ашиглах, операторын апп-аар нэгж дата худалдан авах, цахим банкны аюулгүй байдлын зөвлөмж	Банкны аппликейшнээр дансаа удирдах. Socialpay аппликейшнээр төлбөр тооцоо хийх, онлайнгаар бараа худалдаж авахад анхаарах зөвлөмжүүд
Контент бүтээх / Компьютер хэрэглээ	Богино контент бүтээх, социал медиа дээр контент нийтлэх эсвэл татаж авах, зураг авах, бичлэг хийх, зураг бичлэгээ засварлах, бусдад илгээх	10 хуруугаар шивэх, Word, Excel, Power Point ашиглах

СУУРЬ ТҮВШНИЙ СУРГАЛТЫН ӨМНӨХ АСУУМЖ

Овог, нэр						
Нас (дугуйлах)	55-64	65-69	70-74	75-79	80-84	85+
Хүйс	Эрэгтэй			Эмэгтэй		
Та суралцмаар байгаа сэдвээ эрэмбэлнэ үү. /1- хамгийн чухал, 6- хамгийн бага хэрэгцээт/	Ухаалаг гар утасны суурь ур чадвар					
	Интернэт хэрэглээгээ сайжруулах					
	Цахимаар бусадтай харилцах ур чадвараа сайжруулах					
	Цахимаар төрийн үйлчилгээ авах ур чадвараа сайжруулах					
	Банк, төлбөр тооцооны үйлчилгээг цахимаар авах ур чадвараа сайжруулах					
	Дуу, дүрстэй холбоотой контент бүтээх ур чадвараа сайжруулах					

Ухаалаг гар утасны суурь ур чадвар

Би гар утсаа өөрөө асааж, унтрааж чадна.	Тийм	Үгүй
Би гар утсаа интернет (wi-fi) сүлжээнд холбож чадна.	Тийм	Үгүй
Би гар утсандаа шинэ аппликейшн татаж чадна. (Жиш: Апп стор - App store), Плей стор - Play store)	Тийм	Үгүй
Би гар утсан дээрх аппликейшн болон программыг нээж, ашиглаж чадна.	Тийм	Үгүй
Би гар утсаа хялбар ашиглахад хэрэгтэй тохиргоонуудыг хийж чадна. (Жиш: Уншихад хялбар болгохын тулд үсгийн хэмжээг өөрчлөх, дууг ихэсгэх, багасгах)	Тийм	Үгүй
Би гар утсандаа нууц үг хийж, сольж чадна.	Тийм	Үгүй

Интернэт хэрэглээний ур чадвар		
Би гар утсан дээрээ интернэт браузер суулгаж, ашиглаж чадна.	Тийм	Үгүй
Би хэрэгтэй мэдээллээ интернэтээс хайж чадна. (Жиш: Гүүгл - Google search хайлтын систем)	Тийм	Үгүй
Би Гүүгл Календар (Google Calendar) ашиглан, цагийн хуваарь, тэмдэглэлт өдөр зэргийг тэмдэглэж чадна.	Тийм	Үгүй
Би Гүүгл Фото (Google Photos) дээр өөрийн зургийн цомгийг цэгцэлж чадна.	Тийм	Үгүй
Би гар утсан дээрх өөрт байгаа бүх хаяг бүртгэл рүүгээ нэвтэрч чадна.	Тийм	Үгүй
Би хүүхдийн/ач зээгийнхээ цахим хэрэглээг хянаж чадна.	Тийм	Үгүй
Би өөрийн цахим хаягийнхаа нууц үгийг сэргээж, сольж чадна.	Тийм	Үгүй

Цахимаар бусадтай харилцах ур чадвар		
Би өөрийн гар утсан дээрх интернэтийн дата эрхийг шалгаж чадна.	Тийм	Үгүй
Би гар утсан дээрээ олон нийтийн сүлжээний аппликейшн татаж чадна. (Жиш: Фэйсбүүк - Facebook, Мэссенжер - Messenger), Юүтүб - Youtube)	Тийм	Үгүй
Би бусадтай онлайнаар харилцаж чадна. (Жиш: И-мейл бичих, эсвэл Мэссенжер - Messenger)-ээр харилцах)	Тийм	Үгүй
Би Facebook messenger ашиглан видео дуудлага хийж чадна.	Тийм	Үгүй
Цахим орчинд бусад хүмүүс миний хувийн мэдээллийг авах боломжтой учраас би цахим орчинд хуваалцах зүйлдээ болгоомжтой ханддаг.	Тийм	Үгүй
Би цахим орчинд хуурамч хаягийг таньж, цахим залилангаас сэргийлж чадна.	Тийм	Үгүй

Цахимаар төрийн үйлчилгээ авах ур чадвар		
Би цахимаар төрийн үйлчилгээ авах маягт бөглөх, хүсэлт илгээх зэрэг шаардлагатай үйлдлүүдийг хийж чадна.	Тийм	Үгүй
Би цахимаар эрүүл мэндийн үйлчилгээ авах хүсэлт илгээж, хянаж удирдаж чадна. (Жиш: үзлэгийн цаг захиалах, онлайн зөвлөгөө авах)	Тийм	Үгүй
Би И-Монгол төрийн үйлчилгээний нэгдсэн системд бүртгүүлж, нэвтэрч чадна.	Тийм	Үгүй
Би И-Монгол төрийн үйлчилгээний нэгдсэн системийг өөрийн хэрэгцээндээ бүрэн ашиглаж чадна. (Жиш: Цаг агаар, Лавлагаа, тодорхойлолт авах, Халамжийн үйлчилгээ авах)	Тийм	Үгүй
Би хувийн мэдээллээ цахимаар хамгаалж чадна.	Тийм	Үгүй

Банк, төлбөр тооцооны үйлчилгээг цахимаар авах ур чадвар		
Би банкны цахим хуудас болон аппликейшныг ашиглан дансны гүйлгээ, төлбөр тооцоогоо аюулгүй хийж чадна.	Тийм	Үгүй
Би банкны аппликейшн ашиглан төлбөр тооцоо хийхдээ Qpay ашиглаж чадна.	Тийм	Үгүй
Би банкны аппликейшн ашиглан карт захиалах, данс нээх, дансаа хаах зэрэг бусад үйлчилгээг авч чадна.	Тийм	Үгүй
Би гар утасны оператор компанийн аппликейшнийг ашиглан нэгж, дата худалдан авч чадна. (Mobicom, Unitel, Skytel, G-mobile, Ondo)	Тийм	Үгүй
Би өөрийн хувийн мэдээллийг хамгаалж чадна. (Жиш: бусдад РД, хурууны хээ, нууц дугаараа хэлэхгүй, өгөхгүй байх)	Тийм	Үгүй

Контент бүтээх ур чадвар		
Би гар утсаа ашиглан зураг, дүрс, бичлэг хийж, зургаа эвлүүлж сайжруулж засч чадна.	Тийм	Үгүй
Би олон нийтийн сүлжээнд бусадтай харилцаж, контент нийтэлж чадна. (Жиш: Facebook дээр пост бичих, гэрэл зураг, видео нийтлэх)	Тийм	Үгүй
Би интернэтийг ашиглан энтертайнмент контент хуваалцах эсвэл татаж авч чадна. (Жиш: Youtube-ээр хөгжим сонсох, түүнийгээ бусадтай хуваалцах, кино үзэх, тоглоом тоглох, ном унших)	Тийм	Үгүй

Цахим ур чадвар гэж юу вэ?

Цахим технологи, интернет сүлжээнд холбогдсон төхөөрөмж ашиглан өөрт хэрэгтэй мэдээллээ тодорхойлох, олж авах, түүнийгээ үнэлэх, хуваалцах, нэгтгэх, шинээр бий болгох замаар нийгэм, эдийн засгийн амьдралд оролцох чадварыг хэлнэ.

Мэдээллийн аюулгүй байдал (МАБ)-ын тухай товч ойлголт

Мэдээллийн аюулгүй байдал нь зөвшөөрөлгүйгээр хувийн мэдээлэлд хандах, ашиглах, дэлгэх, алдагдуулах, өөрчлөх, хуулбарлах, устгахаас сэргийлэх дадал юм.

Хүний хувийн мэдээллийн тухай ойлголт

Хүний хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал ("МНАБ") нь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн салшгүй хэсэг бөгөөд энэ хүрээнд хүмүүс хувийн мэдээллээ нууцлах, хамгаалуулах, цаашлаад ямар хувийн мэдээллийг нь хэн цуглуулж, хэрхэн ашиглаж байгааг мэдэх болон хуульд заасны дагуу өөрийн мэдээллийг устгуулах буюу мартагдах эрхтэй юм.